

**Улаанбаатар хотын
Цэвэр агаарын санаачлага 2-р үе**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2012-9 сар



Улаанбаатар хотын цэвэр
агаарын санаачлага 2-р үе
Гэрээний дугаар: 22384/EBSF2009-09-117/01

*Боловсруулсан түлш худалдан авах
чадамж*

2012-9 сар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ЕСБХБ

БОНХЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
0	2012-7-26	Сузанне Рүлофс	Пийт дэ Вилдт		
1	2012-7-31	Сузанне Рүлофс	Пийт дэ Вилдт Онно ван ден Хювэл		
2	2012-09-13		Т. Энхбилгүүн Д. Энхээ		
3	2012-9-14		Г. Ганзориг		

Улаанбаатар хотын цэвэр агаарын санаачлага 2-р үе

Улаанбаатар хотын гэр хороололлын уламжлалт зууханд чанар муутай түүхий нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад хотын агаар бохирдуулагч гол хүчин зүйл болдог. Хотын агаарын чанар нь оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг батлан гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газраас боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас (ЕСБХБ) хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн газартай хамтран 2008 оны 9-р сараас боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний үндсэн хэсгийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьсан. Засгийн газар Үйл ажиллагааны хүрээний баримт бичгийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын тухай багц хуулиудыг баталж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж баримт бичигт заасан гол сгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь уг баримт бичгийн холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгын хүрээнд, зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад

Гарчиг

1	УДИРТГАЛ	3
1.1	УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДОЛ	3
1.2	УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААРЫН САНААЧЛАГА ТӨСЛИЙН 2-Р ҮЕ (УБЦАС II)	3
2	БОЛОВСРУУЛСАН ТҮЛШНИЙ ТҮГЭЭЛТИЙН МЕХАНИЗМ	4
2.1	2011-2012 онд хэрэгжүүлсэн Засгийн газрын туршилтын хөтөлбөр	4
2.2	2012-2013 оны хөтөлбөр	5
3	ТҮЛШНИЙ ХӨНГӨЛӨЛТ	7
3.1	Түлшний хөнгөлөлтөнд тавих босго	7
3.2	Орлогын түвшин	8
3.2.1	Мэдээллийн эх үүсвэр	8
3.2.2	Жинлэгдсэн дундаж	11
3.2.3	Магадлалын түгэлт	12
3.3	ВАУЧЕР	14
4	ДУГНЭЛТ	17

Зураг

Зураг 1: Ваучерын дүн	15
-----------------------------	----

Хүснэгт

Хүснэгт 1: 2011-2012 оны түлшний хэрэглэгчийн үнэ, татаас (төгрөг)	5
Хүснэгт 2: Хувилбартус бүрийн үр дүн, онцлог (төгрөгөөр)	6
Хүснэгт 3: Түлшинд зарцуулах зардал харилцан адилгүй байх үеийн өрхийн орлогын доод хэмжээ (төгрөг)	8
Хүснэгт 4: Судалгаа бүрээр тогтоосон өрхийн сарын дундаж орлого	10
Хүснэгт 5: Хүний хөгжлийн сангийн мөнгийг оруулахгүйгээр тооцсон өрхийн сарын дундаж орлого	11
Хүснэгт 6: Доод хэмжээнээс доогуур орлоготой өрхийн эзлэх хувь	12
Хүснэгт 7: Засгийн газрын нийт зардал (төгрөг)	13
Хүснэгт 8: Татаас, түлшний хөнгөлөлттэй холбоотой гарах Засгийн газрын зардал (төгрөгөөр)	14
Хүснэгт 9: Өрхийн сарын орлогын хэмжээг харгалзан тогтоосон ваучирын дүн	15

Хавсралт

ХАВСРАЛТ 1: НЭМЭЛТ ТЭМДЭГЛЭЛ	18
------------------------------------	----

Товчилсон үгс

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ММСС	Монголын Мянганы сорилтын сан
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НАЧА	Нийслэлийн агаарын чанарын алба
УБЦАС II	Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага 2 төсөл
УИХ	Улсын их хурал
ЦАС	Цэвэр агаарын сан

Оршил

Өнгөрсөн өвөл (2011-2012 он) Засгийн газраас хэрэгжүүлсэн боловсруулсан түлш түгээх туршилтын хөтөлбөр нь боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрснийхээс бага зэрэг доогуур тогтоох замаар гэр хорооллын иргэдэд боловсруулсан түлш худалдан авахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой байлаа. Энэхүү зорилго нь нүүрсний бөөний үнэтэй харьцуулахад биелэгдсэн мэт боловч түүхий нүүрсний жижиглэнгийн үнээс хэт хямд (50 гаруй хувь) байлаа.

Түүхий нүүрс хязгаарлах бүсийн бүх өрх орлогын түвшингээсээ үл хамааран туршилтийн хөтөлбөрт хамрагдав.

Монголын Мянганы сорилтын сангийн (ММСС) захиалгаар судалгаа, зөвлөх үйлчилгээний "ММСС" ХХК 2011 оны 3-р сард явуулсан өрхийн судалгаагаар нэг өрх жилдээ 5.2 тонн түүхий нүүрс, 5.5 м³ мод хэрэглэдэг болох нь тогтоогдсон байна.

Нэг тонн түүхий нүүрсний жишиг үнэ (НАЧА-ны тооцоолсноор) болох 110,000 төгрөгийг (8кг нь 880 төгрөг) ашиглан тооцвол нэг өрхийн жилийн хэрэглээ болох 5.2 тонн түүхий нүүрс бөөний үнээр худалдан авахад 572,000 төгрөг, 1,500 төгрөгний үнэтэй 8кг-ийн шуудайгаар худалдаж авбал 975,000 төгрөг болохоор байна. Эндээс татаасын хэмжээг бууруулан боловсруулсан түлшний жижиглэнгийн үнийг нэмэгдүүлсэн ч өрхийн түүхий нүүрсэнд зарцуулах жилийн зарцуулалтаас бага байхаар харагдаж байна.

Түүхий нүүрс хязгаарлах үндсэн бүсийн өрхийн хэдэн хувьд түлш худалдан авахад нь санхүүгийн дэмжлэг шаардлагатай болохыг тогтоох зорилгоор өрхийн орлогын талаарх мэдээлэл цуглуулсан болно. Айл өрх орон гэрээ боломжийн түвшний дулаантай байлгахын тулд өрхийн орлогын 10-аас дээш хувийг зарцуулах нөхцлийг түлшний ядуурал гэж тодорхойлдог байна. Түүнчлэн өрхийн орлогын 10 хүртэл хувийг цахилгаанд зарцуулахыг хэвийн гэж үздэг байна. Ингэхлээр дээрх хоёр хэрэглээний нийлбэр дээд хязгаар өрхийн орлогын 20% байж болохоор байна. Үүн дээр усны хэрэглээг нэмбэл өрхийн орлогын 25% болдог. Гэр хорооллын цахилгааны хангамж улам сайжирч байгаа тул энэ нь өрхийн түлшинд зарцуулах орлогын хэмжээнд нөлөөлнө. Усны зардал харьцангуй бага тул өрхийн орлогын 15 хүртэлх хувийг боловсруулсан түлшинд зарцуулж болох юм гэж үзэн 15%-ийг түлш худалдан авах чадамж тооцох хязгаар болгон ашигласан болно.

2012-2013 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт түлш худалдан авах чадамжийг дээшлүүлэх төлбөрийг татаастай, татаасгүй аль ч үнээр түлш худалдан авах санхүүгийн чадамж муутай өрхөд олгохыг зөвлөж байна. Холбогдох зардлыг боловсруулсан түлшний татаасын хэмжээг бууруулах замаар нөхөх боломжтой.

1 Удиртгал

1.1 Улаанбаатар хотын агаарын бохирдол

Монгол орны хот суурин газруудын агаарын бохирдол нэн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцорын (2.5 ба 10-ын аль алины) агууламж дэлхийн хэмжээнд хамгийн өндөрт тооцогдож байна. Дэлхийн банкнаас Монгол оронд агаарын бохирдолтой холбоотой гарах эрүүл мэндийн зардал улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 9 орчим хувь, Улаанбаатар хотын ДНБ-ний 19 хувь байна гэх тооцоо гаргасан байна¹. Хот суурин газрын агаарын бохирдлын багагүй хэсэг нь гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээтэй холбоотой. Монгол улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн болон хандивлагч байгууллага бохирдлын асуудалд чиглэсэн олон талын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд уламжлалт зуухыг сайжруулсан зуухаар солих, боловсруулсан түлш нэвтрүүлэх, цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлэх, гэр хорооллын айл өрхүүдийг орон сууцжуулах ажлууд хийгдэж байна. Агаарын бохирдлыг бууруулахад ЕСБХБ-наас ахуйн хэрэглээний түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах, солих чиглэлээр хамтран ажиллаж байна.

1.2 Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 2-р үе (УБЦАС II)

ЕСБХБ-ны Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 1-р үед (2009) боловсруулсан түлш нэвтрүүлэх стратегийг тусгасан Үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч баримт бичгийг боловсруулан гаргасан. Одоогоор төслийн 2-р үе хэрэгжиж байгаа бөгөөд энэ шатанд олон чухал зөвлөмж гарган хэрэгжүүлж байна. Эдгээрийн нэг нь боловсруулсан түлшний түгээлтийн механизм ба өрхийн түлш худалдан авах чадавхийн талаарх зөвлөмж юм. Түүнчлэн “Түлш солих үйл ажиллагааны бүдүүвч” баримт бичигт төслийн хүрээнд боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөр гарган хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг. Гэсэн хэдий ч Засгийн газар өнгөрсөн өвөл (2011-2012) Баянгол дүүргийн зарим хороодыг сонгон боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн билээ. Уг хөтөлбөрийн агуулга, шинж чанар, “Үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт заасан туршилтын хөтөлбөртэй адил байсан учир одоогоор төсөл хөтөлбөрийг боловсронгуй болгох, сайжруулах арга зам, зөвлөмжүүдийг гаргахаар ажиллаж байна. Хөтөлбөрийн механизмын талаар УБЦАС II төслийн тайлан²-д илүү дэлгэрэнгүй оруулсан.

Энэ тайланд өнгөрсөн өвлийн (2011-2012 он) туршилтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн түлшний түгээлтийн механизмд дүн шинжилгээ хийж, ирэх өвөл болон цаашид хэрэглэгчдэд түлш худалдан авахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох талаар санал зөвлөмж орууллаа.

¹ Дэлхийн банк, 2011. Улаанбаатарын агаарын чанарын дүн шинжилгээ –Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд агаарын чанарыг сайжруулах нь.

² УБЦАС, 2012. Боловсруулсан түлшний түгээлтийн хөтөлбөр.

2 Боловсруулсан түлшний түгээлтийн механизм

Монгол улсын Засгийн газраас өнгөрсөн өвөл (2011-2012) Баянгол дүүрэгт боловсруулсан түлш түгээх туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн үр дүнгийн талаар 2012 оны 3-р сард гаргасан “Боловсруулсан түлшний түгээлт-дүн шинжилгээ, зөвлөмж, хэрэгжилт” тайланд (цаашид “3-р сарын тайлан” гэж нэрлэх) дэлгэрэнгүй оруулсан. Боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн нь түүний сургамжинд үндэслэн цаашид хөтөлбөрийг өргөжүүлэх, сайжруулах улмаар түлшний үнийг боломжит хэмжээнд тогтоох механизмын эхлэлийг тавьсан юм.

2.1 2011-2012 онд хэрэгжүүлсэн Засгийн газрын туршилтын хөтөлбөр

2011-2012 оны өвлийн туршилтын хөтөлбөрт Баянгол дүүргийн 7 хорооны 11,578 өрхийг хамруулан хагас кокжсон нүүрс, хагас кокжсон нүүрсэн шахмал түлш, үртсэн шахмал түлш нийлүүлсэн. Эдгээр хороодод түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хэд хэдэн асуудал гарсан ч тэдгээрийн дотор хамгийн том асуудал нь боловсруулсан түлшний нийлүүлэлт хангалтгүй байсан явдал юм. 2011 оны 12-р сарын байдлаар нийлүүлэхээр төлөвлөж байсан түлшний дөнгөж 18%-ийг хэрэглэгчдэд хүргэсэн байв. Энэ нь олон хүмүүсийг түүхий нүүрс хэрэглэхээс аргагүй байдалд хүргэсэн байна. Өөр нэг гол асуудал бол зарим оршин суугчид боловсруулсан түлшийг татаастай үнээр ч худалдаж авах санхүүгийн боломж муутай байгаа учраас янз бүрийн бохирдуулагч түлш хэрэглэсээр л байлаа.

Иймд туршилтын хөтөлбөрийн түлшний үнэ болон түлш худалдан авах хэрэглэгчдийн санхүүгийн чадамжинд дүн шинжилгээ хийж, энэ тайланд тусгасан болно. Эдгээр нь боловсруулсан түлшний хэрэглэгчдэд хүргэх үнэ, мөн өрх бүрт тогтоосон хэмжээгээр түлш олгодог учир өрхийн үлшинд зарцуулсан зардлыг шууд тодорхойлж байдаг.

Хөтөлбөрт хамрагдсан хороодын байнгын оршин суугч өрх бүрт 3 тн боловсруулсан түлш авах ваучер олгосон байна. Хөтөлбөрийн хугацаанд Нийслэлийн Агаарын чанарын алба (НАЧА) түүхий нүүрсний харьцуулах, жишиг үнийг нэг тонн тутамд 90,000 төгрөг байхаар тооцон, уг үнийг (үртсэн шахмал түлшний хувьд бүр доогуур буюу 80,000 төгрөг) үндэслэн түлшний татаасын хэмжээг тогтоожээ. Энэ нь өрх бүрт 2 тонн хагас кокжсон нүүрс ба хагас кокжсон нүүрсэн шахмал түлшний тонн тутмыг 90,000 төгрөгөөр, нэг тонн үртсэн шахмал түлшийг 80,000 төгрөгөөр худалдан авах боломж олгосон гэсэн үг юм. Нэг тонн хагас кокжсон нүүрс ба хагас кокжсон шахмал түлш нийлүүлэх үнэ 150,000 төгрөг, 1 тонн үртсэн шахмал түлшнийх 120,000 төгрөг байсан тул хагас кокжсон нүүрс ба хагас кокжсон шахмал түлшний тонн тутамд 60,000 төгрөгний татаас, үртсэн шахмал түлшний тонн тутамд 40,000 төгрөгний татаас тус тус олгосон. Нэг тонн боловсруулсан түлшний үнийг нэг тонн түүхий нүүрсний үнэтэй ойролцоо, ижил түвшинд байлгах зорилгоор татаасын хэмжээг ингэж тогтоосон байна.

Түүхий нүүрсийг бөөнөөр худалдахаас гадна жижиглэнгийн борлуулагчид уутаар худалдаалдаг. Нүүрсний бөөний ба жижиглэнгийн үнийн хоорондын зөрүү нь нэлээд өндөр байна. Харин туршилтын хөтөлбөрт боловсруулсан түлшний бөөний ба жижиглэнгийн үнэнд ялгаа байгаагүй. Энэ нь аливаа бүтээгдэхүүний бөөний үнэ нь ихэнх тохиолдолд жижиглэнгийн үнээс хямд байдаг зах зээлийн үндсэн зарчмаас ялгаатай байлаа. Хүснэгт 1-ээс харахад нэг уут боловсруулсан түлшний үнэ нэг уут түүхий нүүрсний жижиглэнгийн үнээс нэлээд доогуур байсныг харуулж байна. Татаасгүй байсан ч боловсруулсан түлшний үнэ түүхий нүүрсний жижиглэнгийн үнээс доогуур (түлшийг борлуулагчдад хүргэх, түгээх ба борлуулагчийн ажлын хөлс зэрэг бусад зардлуудыг Засгийн газраас хариуцаж байсан) байх байжээ. “Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт боловсруулсан түлшний жижиглэнгийн үнийг бөөний үнээс арай өндөр байлгахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн боловсруулсан түлшний үнийг хөнгөлөх арга хэмжээг (татаасыг) зөвхөн

санхүүгийн боломж муутай өрх, хэрэглэгчдэд чиглүүлснээр татааст зарцуулах зардлыг нэлээд хэмжээгээр бууруулах боломжтой байна.

	Зах зээлийн үнэ (төг/тн)	Татаас (төг/тн)	Татаастай үнэ (төг/тн)	8кг тутмын үнэ (в/125 ³) (төг/8кг)	Жижиглэнгийн үнэ (төг/8кг)
Багануурын түүхий нүүрс	70,000 ⁴	/	70,000	560	1,300
Налайхын түүхий нүүрс	85,000	/	85,000	680	1,500
Алаг толгойн түүхий нүүрс	85,000	/	85,000	680	1,500
Үртсэн шахмал түлш	120,000	40,000	80,000	640	640
Хагас коксж. нүүрс (шахмал түлш)	150,000	60,000	90,000	720	720
Татаасгүй үртсэн шахмал түлш ⁵	120,000	/	120,000	960	960
Татаасгүй хагас коксж. нүүрс (шахмал түлш)	150,000	/	150,000	1,200	1,200

Хүснэгт 1: 2011-2012 оны түлшний хэрэглэгчийн үнэ, татаас (төгрөг)

2.2 2012-2013 оны хөтөлбөр

Түүхий нүүрсний үнэ өссөөр 2012-2013 оны өвөл 1 тонн нүүрсний харьцуулах жишиг үнэ 110,000 төгрөг гэж НАЧА-наас тогтоосон. Үйлдвэрлэгчийн үнийн дээд хязгаарыг дээрх жишиг үнэ дээр татаасын үнийг нэмж хагас коксжсон нүүрс ба үртсэн шахмал түлшний хувьд 150,000 төгрөг, хагас коксжсон нүүрсэн шахмал түлшний хувьд 170,000 төгрөг гэж тогтоогоод байна.

Өнгөрсөн оныхтой ижил хэмжээний татаас олгогдохоор харагдаж байсан ч 2012 оны 8-р сард Үндэсний хорооноос татаасын хэмжээг бууруулж тогтоосон. Боловсруулсан түлшний түгээлтийн тогтолцооны тайланд тусгагдсан гол зөвлөмжүүд үүнд тусгалаа олсон. Хагас коксжсон түлшний тонн тутамд олгох 40,000 төгрөгний татаасын оронд ЦАС-гаас 20,000 төгрөгний татаас олгохоор болоод байна. Мөн хагас коксжсон шахмал түлшний татаас 60,000 төгрөг байсныг 30,000 төгрөг, үртсэн шахмал түлшнийх 40,000 байсныг 10,000 төгрөг болгож буурууллаа. Ингэснээр шууд татаас 50-75% болон буурсан ба шууд бус татаас хэвээрээ үлдлээ. Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөг дараах хүснэгтүүдэд тод хараар үзүүлээ.

³ Нэг тонн нүүрсийг 8кг-аар ууталбал 125 ширхэг уут болно.

⁴ Багануурын уурхай нь улсын уурхай бөгөөд уг уурхайн үнийг үндэслэн Засгийн газар үнийн түвшинг тогтоосон. Энд өгсөн үнийг зах зээлийн үнэ гэж хатуу заагаагүй ч зах зээлд борлуулагдаж байгаа ердийн үнэ юм. Засгийн газраас түүхий нүүрсний үнийн дээд хязгаарыг мөн тогтоож өгдөг.

⁵ Боловсруулсан түлшинд татаас олгоогүй байсан ч борлуулагчид төлөх үнэ ба борлуулах үнийг Засгийн газраас зохицуулсаар байна.

Энэ жилийн хөтөлбөрт нэг өрхөд 3.5 тн боловсруулсан түлшний ваучер олгохоор төлөвлөж байна. Түүнчлэн өмнөх хороод дээр 2 хороог нэмж нийт 9 хорооны 12,461 өрхөд түлш нийлүүлэхээр төлөвлөж байна. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, НАЧА-наас ирэх өвлийн хөтөлбөрт түлш нийлүүлэгчид, үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг нэлээд бодитоор авч үзсэн гэж байна. Нийлүүлэхээр төлөвлөж буй боловсруулсан түлшний нийт хэмжээ 45,000 тн байна.

Мөн түлш борлуулагчдын тоог ч нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. НАЧА-гаас ирэх өвлийн хөтөлбөрт 9 хороонд 42 борлуулалтын цэг (нэг хороонд 5 орчим цэг) ажилуулахаар санал болгож байна. Өнгөрсөн өвөл түлш борлуулагчдад борлуулсан 1 тонн тутамд 6,000 төгрөг төлж байсан бол энэ өвөл 8,000 төгрөг болгож нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Боловсруулсан түлшний түгээлтийн хөтөлбөрийн тайлан (УБЦАС, 2012)-д 2012-2013 оны хөтөлбөрт зориулан янз бүрийн хувилбар жишээг авч үзлээ. Үүнд Засгийн газрын 2011-2012 онд хэрэгжүүлсэн туршилтын хөтөлбөрийнхөөс (дээр дурьдсан) эхлээд татаасыг бууруулсаар алдагдал, ашиг тэнцэх хүртэлх үеийг оруулав. Хувилбар жишээнд түлшний хэрэглэгчдэд борлуулах үнэ, олгох татаасын үнийг өөр өөрөөр тооцов. Хэдийгээр энэ жилийн хувьд татаас болон түүнээс хамааралтай борлуулалтын үнийг тогтоочихсон боловч эдгээр хувилбарууд дараа дараагийн тооцоо, ирээдүйд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд хэрэг болох болно.

Энд хувилбар жишээнүүдийг товчхон тайлбарлаад хэрэглэгчдийн түлш худалдан авах санхүүгийн чадамж, тэдний зарцуулалтын талаар авч үзлээ. Зарим тайланд өөр хувилбаруудыг авч үзсэн байдаг ч энэ бүх хувилбар жишээнд дээд үнийг (түлш нийлүүлэгчдэд зориулсан) авч хэрэглэлээ.

Хувилбар	Татааст зарцуулах Засгийн газрын зардал	Гарах хэмнэлт*	Боловсруулсан түлшний хэрэглэгчийн дундаж үнэ (төг/8 кг)
Засгийн газрын анхны төлөвлөгөө	Нийт 3.8 тэрбум - Шууд татааст: 2.2 тэрбум; шууд бус татааст: 1.6 тэрбум	0	880
Түүхий нүүрсний үнэтэй тэнцүүлсэн үнэ	Нийт 340 сая - Шууд татаасгүй байхад 0; Шууд бус татааст: 340 сая	3.4 тэрбум	1,500
Хугарлын цэг	0 – Татаасгүй	3.8 тэрбум	1,561
Зөвхөн шууд татаастай	Шууд татааст: 2.2 тэрбум	1.6 тэрбум	1,169
Зөвхөн шууд бус татаастай	Шууд бус татааст: 1.6 тэрбум	2.2 тэрбум	1,271
Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө	Нийт 2.6 тэрбум - шууд татаас: 1 тэрбум Шууд бус татааст: 1.6 тэрбум	1.2 тэрбум	1,099

* Засгийн газрын анхны төлөвлөгөөтэй (3.8 тэрбум төгрөг) харьцуулахад.

Хүснэгт 2: Хувилбартус бүрийн үр дүн, онцлог (төгрөгөөр)

Дээр үзүүлснээр боловсруулсан түлш бүрийн үнийг түүхий нүүрсний жижиглэнгийн үнээс доогуур тогтоосон ч татаасын нийт зардлыг нэлээд бууруулж болохоор байна. Бүх өрхүүдэд татаасыг жигд олгохын оронд ерөнхий үнийн түвшинг нэмэгдүүлэн түлшний хөнгөлөлт (affordability payments) авах шаардлагатай өрхүүдэд олгох хувилбарыг санал болгож байна.

3 Түлшний хөнгөлөлт

Өнгөрсөн жилийн туршилтын хөтөлбөрт түлшийг өндөр татаас бүхий үнээр хэрэглэгчдэд нийлүүлсэн нь татаас олгоогүй бол өрхүүдэд тулгарах байсан санхүүгийн олон бэрхшээлийг шийдэж чаджээ. Боловсруулсан түлшний жижиглэнгийн үнийг бөөний үнээс ялгаатай байлгах ердийн зарчмыг авч үзэхгүйгээр тогтоосон талаар дээр дурьдаж байсан. 2011-2012 оны туршилтын хөтөлбөрт Засгийн газар боловсруулсан түлшний үнийг түүхий нүүрсний үнээс бага зэрэг доогуур тогтоох замаар гэр хорооллын оршин суугчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зорьсон юм. Үнэ тогтоохдоо түүхий нүүрсний бөөний үнийг гол үндэс болгосон. Түүхий нүүрсний жижиглэнгийн үнэтэй харьцуулахад боловсруулсан түлшний борлуулах үнэ нэлээд доогуур буюу түүхий нүүрсний үнийн 50 орчим хувьтай тэнцүү байхаар тогтоосон байлаа. Энэхүү санамсаргүй байдлаар тогтоосон үнийн хөнгөлөлт нь энэ жилийн хөтөлбөрт нөлөөлж байна. Хэдийгээр үнэ байнга өсөх нь эдийн засгийн үндэслэлтэй байдаг ч өнгөрсөн жилийн хямд үнэ нь гэр хорооллын өрхүүдийн дунд ирэх жил болон цаашид ч боловсруулсан түлшний үнэ иймэрхүү хямд байна гэсэн хүлээлтийг бий болгоход хүргэж байна. Иймд боловсруулсан түлшний үнэ тогтоохдоо нэлээд нухацтай авч үзэх шаардлагатай байна.

Онолоор бол татаасын нэлээд хувийг түлш бүрийн үнийг нэмэгдүүлэх замаар нөхөж болно. Энэ нь ялангуяа хөтөлбөрийг өргөжүүлж, тэлээд ирэхээр урт хугацаанд татаасанд өндөр зардал шаардлагатай болох тул бүр ч чухал ач холбогдолтой. Гэхдээ үнийн түвшинг нэмэгдүүлэх тусам түлшний хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай өрхүүдийн тоо нэмэгдэх болно. 2011 оны байдлаар Улаанбаатар хотын ядуурлын түвшин 23.5%-тай байсан байна.

3.1 Түлшний хөнгөлөлтөнд тавих босго

Түлшний хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай хүн амын хувь хэмжээг тогтооход эхлээд хөнгөлөлтийн босго тогтоож өгөх хэрэгтэй. Харамсалтай нь түлшний ядуурал (fuel poverty) ерөнхий тодорхойлолт одоогоор гараагүй байна. Зөвхөн Англи зэрэг цөөн хэдэн оронд зарим тодорхойлолтыг гаргасан байдаг. Англи улсын Засгийн газрын тогтоосноор аливаа өрх өөрийн орлогын 10-аас дээш хувийг орон байраа дулаан байлгах түлшиндээ зарцуулж байгаа бол тухайн өрхийг түлшний ядууралд орсон гэж үздэг байна. “Түлш солих үйл ажиллагааны бүдүүвч” баримт бичигт өрхийн орлогын 10 хүртэлх хувийг цахилгааны хэрэглээнд зарцуулдаг байхаар тооцсон байна. Өрхийн түлш, цахилгаан, усны зардал нийлээд өрхийн зардлын 25%-иас хэтэрсэн тохиолдолд тухайн өрхөд санхүүгийн бэрхшээл тулгарна гэж үзсэн байна. Уг баримт бичиг гарснаас хойш Улаанбаатар хотод усны үнэ ерөнхийдөө хямд байгаа ч цахилгааны үнэ нэмэгдсээр байгаа билээ. Одоогоор түлш, цахилгаан, усанд зарцуулах зардлын 40 хүртэл хувийг цахилгаан, усанд, үлдсэнийг нь түлшинд зарцуулж байгаа гэж үзвэл боловсруулсан түлшинд зарцуулах босго нь өрхийн сарын орлогын 15% байна. Хүснэгт 2-т хувилбар жишээ тус бүрээр хэрэглэгчдийн түлш худалдан авах санхүүгийн чадамж ямар байхыг үзүүлэв.

Өрхийн боловсруулсан түлшний хэрэглээ сарын орлогынх нь 15%-иас хэтрэхгүй байхын тулд өрхийн сарын орлогын доод хэмжээ ямар байх шаардлагатайг хүснэгт 3-т харуулав.

Хувилбар	3.5 тн боловсруулсан түлшинд зарцуулах өрхийн нийт зардал	Сарын зардал	Түлшний зардал < 15% байлгах өрхийн сарын орлогын доод хэмжээ
Засгийн газрын анхны төлөвлөгөө	385,000	32,083	213,887
Түүхий нүүрсний үнэтэй тэнцүүлсэн үнэ	656,250	54,688	364,587
Хугарлын цэг	682,872	56,906	379,373
Зөвхөн шууд татаастай	511,622	42,635	284,233
Зөвхөн шууд бус татаастай	556,250	47,188	314,587
Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө	481,000	40,083	267,222

Хүснэгт 3: Түлшинд зарцуулах зардал харилцан адилгүй байх үеийн өрхийн орлогын доод хэмжээ (төгрөг)

3.2 Орлогын түвшин

Дараагийн алхам бол хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн хэдэн хувь нь Хүснэгт 3-т үзүүлсэн өрхийн доод орлогын түвшингөөс доогуур орлоготой байгааг тооцоолж гаргах явдал юм. Энэ хэсэг бол түлшний хөнгөлөлт (affordability payments) үзүүлэх шаардлагатай өрхүүд болно.

Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын тоо, орлогын хувь хэмжээний талаар үнэн зөв найдвартай, шинэ мэдээлэл олж авах нь нэлээд хүндрэлтэй асуудал байлаа. Ийм төрлийн мэдээллийг өөр өөр байгуулагууд цуглуулдаг ч тэдгээрийн цуглуулсан мэдээлэл хоорондоо зөрүүтэй, тэдний ашигласан аргууд нь ч өөр өөр байдаг байна. Түүнчлэн өрхийн орлогын хувь хэмжээ улирал бүрээр харилцан адилгүй, нэлээд хэлбэлзэлтэй байдаг. Хамгийн гол нь гэр хорооллын оршин суугчдын орлогын талаар албан ёсоор хийсэн бүртгэл судалгаа байхгүй байна. Цалин хөлс, бизнесийн орлого, тэтгэмж зэрэг орлогын эх үүсвэрийн талаар мэдээлэл цуглуулах судалгааг байнга явуулдаг ч уг мэдээлэл, тоог асуулгаар олж авдаг учир орлогын албан ёсны, баталагатай бүртгэл мэдээлэл болж чаддаггүй байна.

Шийдвэр гаргахад туслах үндэслэл болгох үүднээс Үндэсний статистикийн газар, Монголын маркетингийн зөвлөх бүлэг зэрэг аль болох олон эх үүсвэрийн мэдээ мэдээллийг ашиглахыг хичээлээ. Өрхийн сарын орлогын дундаж хэмжээг мэдээллийн эх үүсвэр тус бүрээр үзүүлэв. Цуглуулсан мэдээллээр өрхийн дундаж орлого тус бүрийг тооцож гаргахад хамрагдсан өрхийн тооноос гадна, судалгаа явуулсан газар, судалгааны аргачлал зэрэг хөтөлбөртэй холбогдох бусад хүчин зүйлсээс нь хамааруулан жин өгч тооцов.

3.2.1 Мэдээллийн эх үүсвэр

Монголын маркетингийн зөвлөх бүлэг (судалгаа А1)

Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн 6 хорооны 1,047 өрхийн дунд 2011 оны 3-р сард судалгаа явуулжээ. Уг судалгаагаар өрхийн сарын орлогын дундаж хэмжээг 536,830 төгрөг гэж тогтоосон байна. Судалгаанд гэр болон юмуу байшинд амьдардаг 153,600 өрххамрагджээ. Баянгол дүүргийн 76 өрхийн (судалгаа А2) сарын дундаж орлогыг 515,130 төгрөг гэж тогтоосон байна. Үүнийг орлогын өөр өөр ангилалд хамаарах 76 өрхийн гишүүдтэй уулзаж ярилцах замаар тогтоосон байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо 4.4 байна.

Үндэсний статистикийн газар (судалгаа Б)

Үндэсний статистикийн газрын (ҮСГ) 2011 онд гэр хорооллын 1,874 өрхөөс авсан судалгаагаар сарын дундаж орлогын хэмжээ 564,676 төгрөг байна. Энэ судалгаанд 113,261

өрххамрагджээ. Энэ нь Монголын маркетингийн зөвлөх бүлгийн тогтоосон хэмжээнээс өндөр байна. Гэхдээ энэ судалгаа 2011 оныг бүхэлд нь хамарсан тул дээрх ялгаа нь 2011 оны 3 сараас хойш орлого өссөн, улирлаас хамааран орлогын хэмжээ өөрчлөгдсөн зэргээр тайлбарлагдаж болох юм.

Бусад эх үүсвэр

Түүнчлэн орлогын талаарх мэдээллийг нэмэлт бусад эх үүсвэрээс ч цуглууллаа. Гэхдээ эдгээр мэдээлэл нэг бол нууцлалын зэрэгтэй үгүй бол судалгааны урьдчилсан дүн учраас эх үүсвэрийг энд дурьдсангүй. Цуглуулсан мэдээллийн үр дүн нь нэлээд өргөн зураглалыг өгч байна. Нэмэлт гурван эх үүсвэрийн мэдээлэл нь 200-50,000 орчим өрхийн дунд явуулсан судалгааны дүн юм байна.

Энэ 3 судалгааны (судалгаа В) Монголын маркетингийн зөвлөх бүлгийн судалгаанд хамрагдсан дээрх 6 дүүргийн хүмүүс хамрагдсан байна. Уламжлалт зуух хэрэглэдэг (Баянгол дүүрэгт сайжруулсан зуухыг худалдаагүй) 207 өрхийн сарын дундаж орлогын хамгийн доод⁶ хэмжээ нь 482,164 төгрөг байсан байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо 4.19 байна.

Хоёр дахь судалгаанд (судалгаа Г) Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 4,128 өрхийг хамруулсан. Орлогын сарын дундаж хэмжээ 659,794 төгрөг байсан байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо 7.17 байна. Энэ нь бусад судалгаагаар тогтоосон сарын дундаж орлогын хэмжээнүүдээс нэлээд өндөр харагдаж байна.

Гурав дахь судалгаа (судалгаа Д) нь хамгийн том судалгаа байсан ч түүний хүрээнд гарсан тоо мэдээ нь эргэлзээтэй байна. Судалгаанд хамрагсдыг санамсаргүй байдлаар сонгоогүй. Одоо ч үргэлжилж байгаа уг судалгааны 2011-2012 оных нь үр дүн бусад судалгааны үр дүнгээс нэлээд өөр харагдаж байна. Энэ нь судалгаанд оролцогсдыг сонгосон байдал, хамрагдсан хүмүүсийн хандлагатай холбоотой байж болно. Түүнчлэн судалгаанд оролцогсод өөрт таарах орлогын түвшинг сонгон тэмдэглэхээр судалгааны маягтыг боловсруулсан байна. Орлогын хамгийн дээд хэмжээ 500,000 төгрөг ба түүнээс дээш гэж байгаа нь магадгүй тухайн хүмүүс өөрсдийн өрхийн орлогоо тодорхой сайн тогтоогоогүй учраас ойролцоо байдлаар авч үзсэн байж болно. Энэ нь судалгааны үр дүнг гажуудуулж байж болох татай. Сарын дундаж орлогын хэмжээ 293,435 төгрөг байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо 3.6 байна.

УБЦАС-II төслийн судалгаа (судалгаа Е)

2012-1-4 сард өрхийн орлогын талаарх мэдээллийг 21 өрхөөс цуглуулсан. 1 сард 8 өрх, 4 сард 13 өрхтэй тус тус уулзсан. Уг уулзалтуудын аль алианаас гарсан үр дүнг харахад өрхийн сарын дундаж орлого ойролцоогоор дунджаар 456,095 төгрөг байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо 4.33 байна. Хэдийгээр тухайн өрхүүдтэй уулзан орлогын талаар мэдээлэл цуглуулсан нь статистик мэдээнд дорвитой нөлөөлөхгүй байж болох ч тодорхой хэмжээнд харьцуулалт хийх боломж олгож байна. Түүнчлэн тодорхой түвшнийэсвэл түүнээс доогуур орлоготой өрхүүдийн хувь хэмжээг тооцох зорилгоор энэ мэдээллийг дундаж орлогын түгэлтийн график байгуулахад ашиглалаа. Энэ талаар дараагийн хэсэгт илүү тайлбарлан оруулсан болно.

⁶ Олон судалгаа хийгдсэн. Эдгээр нь урьдчилсан үр дүн болохоор хамгийн уламжлалт аргаар тооцсон тооцоог сонгохоор шийдсэн.

Судалгаа	Өрхийн тоо	Огноо	Байршил (дүүрэг)	Өрхийн сарын дундаж орлого (төгрөгөөр)
A1	1,047	2011-3 сар	Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан уул, Сонгино хайрхан, Сүхбаатар	536,830
A2	76	2011-3 сар	Баянгол	515,130
B	1,874	2011	Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан уул, Сонгинохайрхан, Сүхбаатар	564,676
C	207	2012	Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан уул, Сонгинохайрхан, Сүхбаатар	482,164
D	4,128	2011-2012	Баянзүрх, Чингэлтэй, Сонгино хайрхан	659,794
E	51,028	2011-2012	Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан уул, Сонгино хайрхан, Сүхбаатар	293,435
F	21	2012	Баянгол дүүрэг	456,095

Хүснэгт 4: Судалгаа бүрээр тогтоосон өрхийн сарын дундаж орлого

Анхаарах зүйл

Энд үзүүлсэн тоо нь бүгд дундаж гэдгийг анхаарах хэрэгтэй. Хамгийн гол нь эдгээр судалгаа нь Засгийн газраас нэлээд бэлэн мөнгө /Хүний хөгжлийн сангаас хүн бүрт 21,000 төгрөг 2012-6 сар хүртэл олгосон/ тарааж байх хугацаанд хийгдсэн. Харин ирэх жилийн хөтөлбөрийн хугацаанд эдгээр халамжийн мөнгө тараагдах эсэх нь тодорхойгүй учраас үүнийг анхааралдаа авах хэрэгтэй.

Хүснэгт 5-д өрхийн сарын дундаж орлогоос Хүний хөгжлийн сангаас олгож байсан халамжийн мөнгийг хасаж харьцуулав. Эдгээр дунджийг судалгаа тус бүрээр, хамрагдсан өрхүүдийн гишүүдийн дундаж тоотой нь харьцуулан тооцож гаргасан.

Судалгаа	Өрхийн сарын дундаж орлого (төгрөгөөр) ХХС-гийн мөнгийг оруулан	Өрхийн гишүүдийн дундаж тоо ⁷	Өрхийн сарын дундаж орлого (төгрөгөөр) ХХС-гийн мөнгийг оруулахгүйгээр ⁸
A1	536,830	4.4	444,430
A2	515,130	4.4	422,732
B	564,676	3.7 ⁹	486,976
C	482,164	4.19	394,237
D	659,794	7.17	509,224
E	293,435	3.6	217,835
F	456,095	4.33	365,095

Хүснэгт 5: Хүний хөгжлийн сангийн мөнгийг оруулахгүйгээр тооцсон өрхийн сарын дундаж орлого

3.2.2 Жинлэгдсэн дундаж

Өмнө дурьдсанчлан дээрх мэдээллийн зарим хэсэг нь судалгааны урьдчилсан дүн бол нөгөө хэсэг нь судалгааны аргачлалаасаа шалтгаалан бодит байдлаас хазайсан үр дүн гарсан байж болох талтай. Төслийн зүгээс аль судалгааны үр дүнг баримтлах, ашиглахыг тогтоох боломжгүй учраас Засгийн газар эцсийн шийдвэр гаргахын өмнө илүү нарийвчилсан мэдээ мэдээллийг цуглуулах хэрэгтэй гэж үзэж байна. Гэхдээ дээрх тооцоо, зарчмуудыг үндэслэн УБЦАС-2 төсөл хэд хэдэн хувилбар, жишээг гаргаад байна.

Жин: Судалгаанд хамрагдсан өрхийн тоо

Тооцоонд бүх мэдээллийг чанарын ижил түвшинд, тогтсон хувь хэмжээ болгон авч үзлээ. Энд зөвхөн тухайн судалгаанд хамрагдсан өрхийн тооны жинг дундаж тооцоход тусгаж байгаа гэдгийг санах хэрэгтэй. Энэ тохиолдолд дундаж тус бүрийг г (Хүний хөгжлийн сангийн мөнгийг оруулахгүйгээр) судалгаанд хамрагдсан өрхийн тоогоор нь үржүүлж нийлбэрийг нь бүх судалгаанд хамрагдсан нийт өрхийн тоонд хуваана¹⁰. Ингэж жинлэгдсэн дундаж орлого нь 252,261 төгрөг байна. 50,000 гаруй өрх хамрагдсан судалгаа Д-гийн жин нэлээд өндөр байх нь тодорхой тул жинлэгдсэн дундаж орлого харьцангуй доогуур гарсан байна. Энэ аргад зарим эрсдэл байна. Юу гэвэл хамгийн олон өрх хамарсан том судалгаагаар гарсан дүн нь эргэлзээтэй боловч тооцоонд өндөр жинтэй тооцогдох учир үр дүнд нь жинлэгдсэн дундаж орлого буруу гарсан байж болно. Түүнчлэн уг тооцоонд мэдээллийг нь ашиглаж байгаа судалгааны олонхи нь Баянгол дүүргээс гадна өөр газруудыг хамарсан байгаа юм.

Жин: Байрлал

Хөтөлбөр нэгэнт Баянгол дүүрэгт чиглэж байгаа болохоор уг дүүргээс авсан мэдээ мэдээллийг түлхүү ашиглахыг зорив. Судалгаа А2 ба Д нь зөвхөн тус дүүргийг оруулсан болохоор уг судалгааны мэдээллийг авч харин судалгаа А1 ба Г-г оруулсангүй. Судалгаа Д-гийн мэдээллийг нь эргэлзээтэй (дээр дурьдсанчлан) гэж үзсэн учир түүнийг мөн авч үзсэнгүй. Бусад судалгааны хувьд бүгд 6 дүүргийг нэг ижил хамарсан байна. Баянгол дүүргийн өрхийн тооны эзлэх хувь нь $48,596/167,196=0.29$ байна. Хэдийгээр энд гаргасан

⁷ Судалгаа бүрийн мэдээгээр.

⁸ = ХХС-гийн мөнгийг оруулсан өрхийн сарын дундаж орлого – өрхийн гишүүдийн дундаж тоо * 21,000 төгрөг

⁹ Монгол улсын Статистикийн 2011 оны тайлан; УБ хотын хэмжээнд авч үзсэн.

¹⁰ Судалгаа А2 нь А1-ийн нэг хэсэг учраас оруулаагүй.

өрхийн сарын дундаж орлого нь яг нарийн тогтоосон тоо биш ч Баянгол дүүргийн хувьд ойролцоогоор авч үзэх боломж олгох болно. Баянгол дүүргийн хувьд ойролцоо тооцоог гаргасан болно. Ийм орлогын хувьд өрхийн сарын дундаж орлого нь 468,399 төгрөг. Энэ нь судалгаанд хамрагдсан өрхийн тоогоор нь жинлэх аргаар тооцож гаргасан жинлэгдсэн дунджаас нэлээд өндөр байна.

3.2.3 Магадлалын түгэлт

Өрхийн сарын дундаж орлогыг тооцохын зэрэгцээ энэ хэмжигдэхүүний магадлалын түгэлт ямар байгааг олж мэдэх нь чухал. Тооцоход амрыг нь бодолцож нормаль түгэлтийг авч үзэв. Гэхдээ бодит байдал дээр өрхийн орлого нормаль түгэлттэй байдаггүй, ихэвчлэн хазайх хандлагатай байдгийг санах хэрэгтэй. Энэ талаар цаашид үргэлжлүүлэн авч үзэх болно.

Өрхийн орлогын магадлалын түгэлтийг тоймлон гаргахад судалгаа E-гийн дундаж орлогын хэмжээг ашиглав. Жишээ болгон авсан уг судалгаанд хамрагдсан өрхийн тоо нь цөөхөн боловч эндээс тооцсон өрхийн сарын дундаж орлогын утга нь жинлэгдсэн хоёр дунджийн яг дундаж байгаагаас гадна өрх тус бүрийн орлогын мэдээлэл нь ч бидэнд байгаа юм.

Судалгаа E-гийн өрхийн сарын дундаж орлого 365,095 төгрөг, стандарт хазайлт нь 224,423 төгрөг байна. Хүснэгт 3-т үзүүлсэн өрхийн орлогын доод хэмжээнээс доогуур орлоготой өрхүүдийн хувь хэмжээг Хүснэгт 6-д харууллаа.

Хувилбар	Түлшний зардал < 15% байх өрхийн сарын орлогын доод хэмжээ	Түлшний зардал < 15% байх өрхийн сарын доод орлогоос доогуур орлоготой өрхийн эзлэх хувь
Засгийн газрын анхны төлөвлөгөө	213,887	25%
Түүхий нүүрсний үнэтэй тэнцүүлсэн үнэ	364,587	50%
Хугарлын цэг	379,373	52%
Зөвхөн шууд татаастай	284,233	36%
Зөвхөн шууд бус татаастай	314,587	41%
Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө	267,222	33%

Хүснэгт 6: Доод хэмжээнээс доогуур орлоготой өрхийн эзлэх хувь

Гэр, байшинд амьдардаг айл өрх бүр доод тал нь сарын 100,000 төгрөгний орлоготой гэж үзэж байна. Учир нь сарын цалин хөлсний доод хэмжээ, тэтгэвэр, хөдөлмөрийн чадваргүй иргэдэд олгодог тэтгэмж зэрэг нь бүгд 100,000 төгрөгөөс дээш байна. Иймд өрх бүр боловсруулсан түлшинд сард доод тал нь 15,000 төгрөг зарцуулах боломжтой гэсэн үг юм. Энэ тоог хэрэглэгчдэд үзүүлэх боловсруулсан түлшний хөнгөлөлтөнд зарцуулах зардал тооцох хамгийн доод хязгаараар, өрхийн түлшний бодит зардлыг дээд хязгаараар авлаа.

Хөтөлбөрийг аль хувилбараар хэрэгжүүлэхээс хамааран Засгийн газраас түлшний хөнгөлөлтөнд зарцуулах зардал нь харилцан адилгүй байх нь харагдаж байна. Зардлыг хувилбар бүрээр тооцоход сарын дундаж зардлыг үндэслэв. Тухайлбал: Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөг авч үзвэл татаас олгосон ч оршин суугчдын 33% нь 3.5 тн боловсруулсан түлшээ худалдан авч чадахгүй байна. Хүснэгт 3 ба 7-д үзүүлснээр энэ хувилбараар нэг өрх сард 40,083 төгрөг түлшинд зарцуулна. Түлшээ худалдан авах

санхүүгийн чадамж муутай 33%-д (15%-ийн босгоор тооцвол) багтаж буй өрхүүдийн дотор уг тогтоосон босгод ойртох орлоготой тул арай бага дэмжлэг шаардлагатай өрх ч бий, Түлшээ огт худалдаж авах чадамжгүй тул бүхэлд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай өрх ч бий.

Дээрхэд үндэслэн Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөнд тусгасан татаасын хэмжээг авч үзвэл нэг өрхөд олгох түлшний хөнгөлөлт сард доод тал нь 1 төгрөг, дээд тал нь 25,083¹¹ төгрөг байна. Нэг өрхөд 3.5 тн түлш хуваарилахаар тооцвол 12,857 өрхөд 45,000 тн түлш нийлүүлэх хэрэгтэй. Эдгээр өрхийн ойролцоогоор 33% буюу 4,243 өрх нь уг түлшийг худалдан авах санхүүгийн чадамж муутай бөгөөд нэг өрхөд сард дунджаар 12,542¹² төгрөг (буюу жилд 150,504 төгрөг)-ийн хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй. Засгийн газраас үүнд гарах нийт зардал 600 сая гаруй төгрөг болно. Бусад хувилбаруудад ч дээрхтэй ижил тооцоо хийснээ Хүснэгт 7-д үзүүлэв.

Хувилбар	Нэг өрхийн сарын түлшний зардал	Түлшний хөнгөлөлтөнд зарцуулах Засгийн газрын нийт зардал
Засгийн газрын анхны төлөвлөгөө	32,083	329,473,482
Түүхий нүүрсний үнэтэй тэнцүүлсэн үнэ	54,688	1,530,844,419
Хугарлын цэг	56,906	1,681,050,693
Зөвхөн шууд татаастай	42,635	767,482,672
Зөвхөн шууд бус татаастай	47,188	1,018,080,774
Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө	1.1 40,083	1.2 368,588,472

Хүснэгт 7: Засгийн газрын нийт зардал (төгрөг)

УБЦАС-2 төслийн Боловсруулсан түлш түгээлтийн хөтөлбөрийн тайланд боловсруулсан түлш бүрт олгох татаасын зардлыг авч үзсэн. Иймд хувилбар бүрээр ерөнхий зардлуудыг харуулах үүднээс уг зардлыг түлшний хөнгөлөлтөнд гарах зардалтай нэгтгэж харууллаа (Хүснэгт 8).

¹¹ = 40,083 - 15,000 төгрөг

¹² = (1 + 25,083 төгрөг) / 2

Хувилбар	Татаасын зардал	Түлшний хөнгөлөлтөнд зарцуулах зардал	Засгийн газрын нийт зардал
Засгийн газрын анхны төлөвлөгөө	3.8 тэрбум	329 сая ¹³	4.1 тэрбум
Түүхий нүүрсний үнэтэй тэнцүүлсэн үнэ	340 сая	1.5 тэрбум	1.8 тэрбум
Хугарлын цэг	0	1.7 тэрбум	1.7 тэрбум
Зөвхөн ууд татаастай	2.2 тэрбум	767 сая	3 тэрбум
Зөвхөн шууд бус татаастай	1.6 тэрбум	1 тэрбум	2.6 тэрбум
Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө	2.6 тэрбум	639 тэрбум	3.2 тэрбум

Хүснэгт 8: Татаас, түлшний хөнгөлөлттэй холбоотой гарах Засгийн газрын зардал (төгрөгөөр)


Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөгөөр нийт зардал 3.2 тэрбум төгрөг байна. Энэ нь анхны төлөвлөгөөнөөс 900 сая төгрөгөөр доогуур байна. Бусад хувилбарын хувьд мэдээж татаасын хэмжээ хамгийн бага байхад Засгийн газрын зардал хамгийн бага, харин өндөр байхад хамгийн өндөр байна. Хамгийн гол нь татаасын хэмжээг бууруулж, дэмжлэг шаардлагатай өрхүүдэд үзүүлэх түлшний хөнгөлөлт нэмэгдүүлэхэд Засгийн газрын анхны төлөвлөгөөтэй харьцуулахад гарах зардал нь ямар ч тохиолдолд бага байна. Түлшний хөнгөлөлт эзнээ олж буй эсэхэд хяналт, мониторинг тавихад бага зэрэг илүү зардал гарах хэдий ч Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөнд тусгасанчлан татаасыг ерөнхийд нь бууруулж, боловсруулсан түлшний хөнгөлөлтийг санхүүгийн дэмжлэг шаардлагатай өрхүүдэд чиглүүлсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь зүйтэй. Засгийн газрын анхны төлөвлөгөөгөөр (түлшний хөнгөлөлтийн нэмэлт зардал байгаагүй) бол оршин суугчдын 25% нь түлш худалдан авахад санхүүгийн хүндрэлтэй байсан бол бусад хувилбарын тухайд хэрэглэгчдэд ямар нэг санхүүгийн асуудал хүндрэл гарахааргүй байна. Хэдийгээр энд хэрэглэсэн өрхийн сарын дундаж орлогуудын утга нь нарийн таараагүй байж мэдэх ч тооцоолсан арга нь ижил бөгөөд аль ч хувилбарыг авч хэрэгжүүлсэн ч хэмнэлттэй, илүү үр өгөөжтэй байхаар байна.

3.3 Ваучер

Түлшний нэмэлт хөнгөлөлт олгох шаардлагатай өрхүүдийн тоо нь таатаасын аль хувилбарын сонгохоос шууд хамаарч байна (Хүснэгт 6). Яагаад гэвэл хувилбар бүрт ямар нэг хэмжээний түлшний хөнгөлөлт байна. Энд өгсөн хувилбар бүрийн тооцоонд хөнгөлөлтийн нэг ижил түвшинг авч үзэв. Гэхдээ орлогын хэмжээ харилцан адилгүй өрхүүдийн хэрэгцээг хангахын тулд түлшний хөнгөлөлтийн өөр өөр түвшинг тогтоож ашиглах хэрэгтэй. Хөнгөлөлтийн хэдий олон түвшинг тогтооно хөнгөлөлт тэр хэмжээгээр хэрэгцээ, шаардлагад илүү нийцэх ч хэрэгжүүлэхэд илүү хүндрэлтэй юм. Өрхийн орлогын бодитой мэдээлэл хангалтгүй хязгаарлагдмал байх тусам түлшний хөнгөлөлт олгох тогтолцоо түүгээр хязгаарлагдаж, хөнгөлөлтийн түвшингийн тоо цөөн болно. Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөөний илүү бодитой нөхцлөөр тооцвол түлшний хөнгөлөлтийн нийт зардал 639 сая төгрөг, нэг өрхөд олгох сарын хөнгөлөлт дундажаар 12,542 төгрөг (жилд 150,504 төгрөг) байна. Ийм ганц дундаж тоо ашиглахын оронд өрхүүдийг орлогын түвшингээр нь хөнгөлөлтийн бүлгүүдэд хуваах нь илүү оновчтой болох юм. Бид түлшний хөнгөлөлтийн хоёр түвшинг тогтоох санал дэвшүүлж байна.

¹³ Төлөвлөсөн зардал биш. Харьцуулах үүднээс оруулав

Дараах хоёр түвшинтэй хөтөлбөрийг санал болгож байна: Нийт хөнгөлөлт эдлэх шаардлагатай өрхийн (4,243 өрх) ойролцоогоор 50% нь эхний бүлэгт хамрагдаж түлшний хөнгөлөлтийн дээд хэмжээний 1/4-ийг (6,270 төгрөг); үлдэх 50% нь 3/4-ийг (18,813 төгрөг) авах юм.



Зураг 1: Ваучерын дүн

Өрхүүдэд түлшний хөнгөлөлтийг хоёр түвшинд ялгавартай тогтоосон “түлшний хөнгөлөлтийн ваучер”-аар дамжуулан үзүүлж болно. Дараахи тооцоонд өрхийн орлогыг үндэслэн хөнгөлөлтийн аль түвшинд хамаарч болохыг авч үзэв. Засгийн газрын өнөөгийн төлөвлөгөө хувилбарт өрх нь боловсруулсан түлшний зардлаа орлогынхоо 15%-иас хэтрүүлэхгүй байхын тулд сард 267,222 төгрөгнөөс дээш орлоготой байх шаардлагатай болно. Энэ түвшингээс дөнгөж доогуур орлоготой өрхүүдийг “1”-р бүлэгт оруулав (Зураг 1). Сарын өрхийн орлогын доод хэмжээ нь 100,000 төгрөг бүхий өрхүүд сар бүр түлшиндээ 15,000 төгрөг зарцуулах босготой. Нэг сарын түлшинд шаардагдах зардал 40,083 төгрөгт хүрэхийн тулд 25,083 төгрөгийн тусламж хэрэгтэй болно (Хүснэгт 3, 7). Иймд нөгөө бүлэг буюу хязгаар нь 25,083 төгрөг болно.

Хоёр ангилалд хуваахын тулд хязгаар хоорондын бүсийг хоёр хэсэгт хувааж үзэв. Ангилалын дээд ба доод утгын дундаж нь түлшний хөнгөлөлт үзүүлэх хэмжээ болно. Өрхийн орлогын 15%-ийн босго дотор байлгахын тулд 1-12,542 төгрөг шаардлагатай өрхүүд 6,270 төгрөгийн хөнгөлөлт авна гэсэн үг юм. Энд хийсэн тооцоо нь: 12,542 төгрөгийн дэмжлэг авах шаардлагатай өрх гэдэг нь $40,083 - 12,542 = 27,541$ төгрөгийг өөрийн орлогоосоо түлшиндээ зарцуулах боломжтой бөгөөд энэ нь өрхийн орлогын 15%-иас хэтрэхгүй байна Өөрөөр хэлбэл өрхийн сарын доод орлого нь 183,607 төгрөг байна гэсэн үг юм. Бусад дундаж утгыг ижил аргаар тооцон Хүснэгт 9-д үзүүлэв. Хэдийгээр энд тооцоог сараар хийсэн байгаа ч ваучерыг тараах зэрэг зохицуулалтын ажиллагаанд гарах хүндрэлээс зайлсхийж, хөнгөлөлтийн ваучерыг аль болох урт хугацаагаар тараах нь зүйтэй.

Өрхийн тоо	Өрхийн сарын орлогын хэмжээ (төгрөгөөр)	Сарын ваучерын дүн (төгрөг)
2,122	100,000 – 183,607	18,813
2,122	183,607 – 267,221	6,270

Хүснэгт 9: Өрхийн сарын орлогын хэмжээг харгалзан тогтоосон ваучерын дүн

Түлшний хөнгөлөлтийн нийт зардлыг хувилбар бүрээр тооцож гаргав. Иймд төсвийг хороо, хэсэг бүрээр гаргаж ваучерыг нэгж бүрт тарааж болно. Нэг ажилтан (эсвэл баг) түлшний

хөнгөлөлтийн тусламж хэрэгтэй байгаа өрхүүдэд ваучер тараах ажлыг хариуцан явуулж болно. Ваучерыг тусламж дэмжлэг шаардлагатай өрхүүдэд бус харин өөр бусад өрхүүдэд тараах явдал гарч болох учраас энэ тогтолцоо нь нэлээд сайн хяналт шаардана. Гэхдээ одоогоор өрхийн орлогын талаар найдвартай бүртгэл судалгааны тогтолцоо байхгүй тул тухайн газар, өрх айлуудын нөхцөл байдлыг сайн мэдэх ажилтнууд ваучерыг тараах ажлыг хариуцах нь зүйтэй. Түлш татаастай ч гэсэн 3.5 тн түлшний ваучер авсан өрх бүр түлшээ мөнгөөр худалдаж авах шаардлагатай болно. Түлшний хөнгөлөлтийн ваучер нь тодорхой үнэ цэнэ бүхий мөнгө учраас түүгээр түлш борлуулах цэгүүдээс боловсруулсан түлш худалдаж авахад ашиглаж болно. Түлш борлуулагчид борлуулалтын явцад түлш худалдаж авсан хөнгөлөлтийн ваучеруудыг цуглуулан тэдгээрийг мөнгөөр солих ба ЦАС-гийн дансанд дүнг байршуулж болно.

Түлш худалдан авах санхүүгийн дэмжлэгийн энэ асуудлыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны хариуцах ажлын нэг хэсэг болгон оруулах зөвлөмжийг санал болгож байгаа бөгөөд яамнаас өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай бүлэгт түлшний халамж олгодог. Түүнчлэн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас түлшний халамжинд бэлэн мөнгө олгодог тул түлшний хөнгөлөлтийг иргэдэд зориулалтаар нь ашиглуулах үүднээс ваучерийн тогтолцоог зөвлөж байгаа болно. Энэ асуудлыг холбогдох байгууллагууд болох Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Үндэсний хороо, ЦАС, НАЧА зэрэгтэй холбогдон цаашид хэлэлцэх болно.

4 Дүгнэлт

Зарим өрх боловсруулсан түлшийг ямарч үнээр худалдан авах санхүүгийн чадамж муутай байдаг тул эдгээр өрхүүдэд түлш худалдан авах чадамжийг нь дээшлүүлэх тусгай хөнгөлөлт олгох асуудлыг санал болгож байна. Боловсруулсан түлшний түгээлтийн зохих загварыг боловсруулах шаарлагатай бөгөөд түлш худалдан авах санхүүгийн чадамжийг дээшлүүлэх төлбөрийг Хүн амын хөгжил, нийгмийн халамжийн ямаар дамжуулан ваучер юмуу бэлэн мөнгө хэлбэрээр хийх боломжтой. Түлшний түгээлтийн хөтөлбөрт түлш хөнгөлөлт нь нэмэлт зардал болон тусах учраас татаасын хэмжээг багасгах замаар уг зардлыг гаргах боломжтой.

Хавсралт 1: Нэмэлт тэмдэглэл

Гэрээний нэр:	Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага – II үе – Төслийн хяналт удирдлага
Тайлангийн нэр:	Боловсруулсан түлш худалдан авах чадамж
Захиалагч	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Захиалагчийн гэрээний дугаар	C22384/EBSF-2009-09-117/01
Захиалагчийн холбогдох мэдээлэл:	БОНХЯ, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар Засгийн газрын байр II Нэгдсэн Үндэстний гудамж 5/2 Улаанбаатар хот-210646 Монгол улс
Зөвлөх	Евроконсалт Мотт Макдоналд Амстердамсевег 15, Арнхем Шуудангийн хайрцаг 441 6800 АК Арнхем Нидерланд улс Утас: +31 (0) 26 357 7111, Факс: +31 (0) 26 357 7577 И-мэйл: euroconsult@mottmac.nl , веб хуудас: www.euroconsult.nl
Гэрээний менежер/ Төслийн захирал	Каролин ла Чапелл И-мэйл: caroline.lachapelle@mottmac.nl
Багийн ахлагч/ Төслийн менежер	Пиет де Вилдт И-мэйл: piet.wildt@mottmac.nl